# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

| | |
|---|---|
| ДУГААР | 151021-31 |
| ХАВСРАЛТ | 1 |
| ОГНОО | 2022 оны 09-р сарын 02-ны өдөр |
| УТГА | Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай |

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("**Компани**")-ийн Хоол үйлдвэрлэлийн төвийн хөлдөөх болон хүйтэн агуулахын өргөтгөлийн 2-р шатны барилгын ажлыг гүйцэтгэх ерөнхий гүйцэтгэгчээр Компанийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд болох Премиум Прожектс ХХК-ийг сонгох тухай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг авч хэлэлцээд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дох заалт, 91 дүгээр зүйлийн 91.2 дох заалт, Компанийн Дүрмийн 9.4.18 дох заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Хоол үйлдвэрлэлийн төвийн хөлдөөх болон хүйтэн агуулахын өргөтгөлийн 2-р шатны барилгын ажлыг гүйцэтгэх ерөнхий гүйцэтгэгчээр Премиум Прожектс ХХК-ийг сонгосугай.

2. Премиум Прожектс ХХК-тай байгуулах Хүнсний үйлдвэрийн өргөтгөлийн ажлын 2-р үе шатны гүйцэтгэлийн гэрээг Хавсралт 1-ээр баталсугай.

3. Премиум Прожектс ХХК-тай байгуулах Хүнсний үйлдвэрийн өргөтгөлийн ажлын 2-р үе шатны гүйцэтгэлийн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д олгосугай.

4. Энэхүү тогтоолд Компанийн тухай хуулийн дээр дурдсан холбогдох заалтуудыг үндэслэн сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүд санал өгөхөөс түтгэлзсэн болохыг дурдсугай.

(*Гарын үсгийн хуудас дагалдана*)

ДУГААР 151021-31

ОГНОО 2022 оны 09-р сарын 02-ны өдөр

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК
CENTRAL EXPRESS CVS JSC
УЛААНБААТАР ХОТ
9022010245 5165004 ШЖР0471

| | | ЗӨВШӨӨРСӨН | ТАТГАЛЗСАН | ТҮДГЭЛЗСЭН |
|---|---|---|---|---|
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: | А.ГАНХУЯГ | | | [signature] |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД: | А.ГАНБОЛД | | | [signature] |
| | О.БАТМӨНХ | | | [signature] |
| | Г.БАТ-ЭРДЭНЭ | | | [signature] |
| | Г.ЧИНЗОРИГ | [signature] | | |
| | Б.БАТ-ЭРДЭНЭ | [signature] | | |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД: | Н.ЭНХБОЛД | [signature] | | |
| | В.ГАНЗОРИГ | [signature] | | |
| | ГАРИ СТИВЕН БИОНДО | [signature] | | |
| ТОГТООЛЫН БАТЛАГДСАН ХУВЬ: | | 100% | | |